



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/015/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Бадрал Утас: 91983443 Цахим хаяг: badralts@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Д.ЭНХБОЛД
ТАНАА

2025.03.25. № 2/МТ
танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, шинж чанарын хувьд материаллаг, илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Соёлын төвд сандал нийлүүлэх" тендерийг үнэлгээний хороо хуралдуулалгүйгээр гэрээ байгуулсан,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ажлуудыг хүлээн аваагүй, улсын комиссын актгүй байхад журам зөрчиж эцсийн санхүүжилт олгосон, барьцаа чөлөөлөхдөө журамд заасан баримт бичигт үндэслэхгүйгээр олгосон,
- 2024 онд "ЕБС-ийн засвар тохижилт", "ЕБС-ийн дотуур байрны паркетэн шал солих" гэсэн 2 тендерийг зохион байгуулахдаа хэрхэн үнэлсэн талаар нотлох баримт материалгүй, цахимаар ирүүлсэн материалыг задалж нээн үзээгүйгээр шалгаруулж гэрээ байгуулсан,
- Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журам мөрдөж ажиллаагүй,

- Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичиг бүрдүүлж архивлаагүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөөгүй, үнэлгээний хорооноос зөвлөмж гаргаж Засаг даргад хүргүүлээгүй,
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөвгүй тусган санхүүжүүлсэн,

Асуудлыг онцолсон хэсэг

Буянт сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 1,013,491.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 293,797.7 мянган төгрөг буюу 40.8 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	512,901.4	1,184,324.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	136,778.9	725,763.2
33	АВЛАГА	267,320.6	237,582.6
34	УРЬДЧИЛГАА	35,376.1	148,730.5
35	БАРАА МАТЕРИАЛ	73,425.8	68,648.4
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	3,600.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,361,400.7	4,767,100.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,361,400.7	4,767,100.4
39200	Биет хөрөнгө	3,015,055.3	4,420,755.0
39300	Биет бус хөрөнгө	346,345.4	346,345.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,874,302.1	5,951,425.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,743.2	2,984.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,743.2	2,984.3
41300	Өглөг	20,743.2	2,984.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,853,558.8	5,948,440.8
51	Засгийн газрын хувь оролцоо	3,853,558.8	5,948,440.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	781,027.5	781,027.5
51200	Хуримтлагдсан үр дүн	2,770,324.6	4,865,206.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,206.8	302,206.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,874,302.1	5,951,425.1

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,026,689.3	4,201,491.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	394,657.2	1,001,275.6
110	Орлогын албан татвар	232,138.5	523,611.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	250,403.1	539,996.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,264.6	-16,385.0
113	Хөрөнгийн албан татвар	56,849.6	269,282.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,669.1	208,381.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,647,132.2	1,741,334.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,647,132.2	1,740,014.3
121	Хөрөнгийн орлого	0.0	1,320.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	984,899.9	1,458,881.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,509,341.1	2,106,609.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,341.1	2,106,609.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,507,996.1	2,073,810.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	490,762.5	769,103.7

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,085.4	94,700.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,168.7	262,827.9
2104	Хангамж, бараа материалын зардал	427,071.7	384,100.3
2105	Нормативт зардал	0.0	553.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,300.1	12,986.0
2107	Томилолт, зочны зардал	7,495.7	7,314.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	309,103.5	38,239.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,008.4	503,985.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,345.0	32,798.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,517,348.2	2,094,882.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,517,348.2	2,094,882.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,375,827.6	2,562,548.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	394,657.2	1,001,275.6
110	Орлогын албан татвар	232,138.5	523,611.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	250,403.1	539,996.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,264.6	-16,385.0
113	Хөрөнгийн албан татвар	56,849.6	269,282.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,669.1	208,381.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	49,734.1	21,997.4
1181	Газрын төлбөр	26,905.0	155,653.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	29,030.0	30,730.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,409.5	102,391.1
120	Нийтлэг татварын бус орлого	86,409.5	101,071.1
121	Хөрөнгийн орлого	0.0	1,320.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,894,760.9	1,458,881.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,910,974.0	1,496,383.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,910,974.0	1,496,383.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	999,767.9	1,463,585.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	496,854.7	789,194.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,063.2	96,423.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,242.0	262,827.9
2104	Хангамж, бараа материалын зардал	34,407.3	29,025.9
2105	Нормативт зардал	502.5	553.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,237.3	12,986.0
2107	Томилолт, зочны зардал	5,763.3	7,314.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	332,660.0	52,607.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,037.6	212,652.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	911,206.1	32,798.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	464,853.7	1,066,164.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	349,836.2	474,710.1

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	349,836.2	474,710.1
2200	Дотоод эх үүсвэрээр	349,836.2	474,710.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-349,836.2	-474,710.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-15,100.0	-2,470.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	15,100.0	2,470.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	99,917.5	588,984.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,861.4	136,778.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	136,778.9	725,763.2

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,336,210.7	2,336,210.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,336,210.7	2,336,210.7
9	Тайлант үеийн үр дүн	1,517,348.2	1,517,348.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,853,558.8	3,853,558.8
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,853,558.8	3,853,558.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,853,558.8	3,853,558.8
19	Тайлант үеийн үр дүн	2,094,882.0	2,094,882.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,948,440.8	5,948,440.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,216,793.60	1,833,018.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,375,677.40	1,355,838.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,342,401.40	1,323,039.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	796,594.60	789,194.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,837.20	96,423.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,608.20	262,827.90
2104	Хангамж, бараа материалын зардал	28,847.20	28,525.90
2105	Нормативт зардал	553.7	553.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,986.80	12,986.00
2107	Томилолт, зочны зардал	7,603.10	7,314.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,742.10	44,667.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,628.50	80,546.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,276.00	32,798.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,276.00	32,798.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	717,314.00	474,710.10

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	123,802.20	2,470.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,216,793.60	2,045,090.80
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,015,588.50	1,953,600.70
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	201,205.10	91,490.20
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	70,226.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	282,299.30

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Код	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160,882.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,882.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,545.60
2104	Хангамж, бараа материалын зардал	500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,105.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,336.40
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,336.40
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	160,882.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,882.10

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,074,403.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,074,403.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:

- Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан - 82,559.9 мянган төгрөг,
- Тухайн жилд ногдох хүү, алданги тооцож тайланд тусгаагүй -5,444.6 мянган төгрөг,

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө, нийт эх үүсвэрээс зөрүүтэй – 5,504.3 мянган төгрөг,
- Үр дүнгийн тайлангийн орлого, зарлагыг зөрүүтэй тайлагнасан – 146,210.5 мянган төгрөг,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан төлөвлөгөөгүй, эх үүсвэр байхгүй, зарлагын дүн зөрүүтэй тайлагнасан – 717,314.0 мянган төгрөг,
- Хүлээн аваагүй, ажил бүрэн хийгдэж дуусаагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрсөн – 117,370.5 мянган төгрөг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, шинж чанарын хувьд материаллаг, өргөн тархалттай байгаа тул “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 300,618.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 161,363.9 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 21,109.8 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, 118,144.5 мянган төгрөгийн 2 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

3.1 Албан шаардлага

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг журам зөрчиж улсын комиссын актгүй, хүлээн аваагүй байхад эцсийн санхүүжилт олгосон, “Цэцэрлэгийн тохижилт, хаалганы засвар”-ын ажлыг 2025.03.31-нийг дуустал сунгасан байхад эцсийн санхүүжилтийг олгосон, барьцаа чөлөөлөхдөө журамд заасан баримт бичигт үндэслэхгүйгээр олгож байгаа нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.3.6-д “Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилт нь гэрээний нийт дүнгийн үлдэгдэл буюу хамгийн багадаа 10 хувиас багагүй байх ба эцсийн санхүүжилтийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын дүгнэлт гарсны дараа олгох бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж, эх хувь гэсэн баримт бичгийн хувьд цаасаар, бусад баримт бичгийг цахим системээр ирүүлнэ.”, 4.3.6.1-д “санхүүжилт хүссэн албан бичгийн эх хувь”, 4.3.6.11-д “байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт эх хувь”, 4.3.6.16-д “гэрээ дүгнэсэн акт эх хувь”, 4.3.6.18-д “тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан акт” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

3.2 Зөвлөмж

3.2.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээний гэрээ байгуулан санхүүжилт олгохдоо 70:30 харьцаагаар олгож байгаа нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.3.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг энэ журамд зааснаар олгох бөгөөд цахим системд ангиллаас хамаарч бүрдүүлэх материалыг удирдлага болгож, санхүүжилтийг дараах байдлаар ангилна:”. 4.3.1.1-д “эхний санхүүжилт;”, 4.3.1.2-д “дундын буюу явцын санхүүжилт”, 4.3.1.3-д “эцсийн буюу бүрэн санхүүжилт”, 4.8.13-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу санхүүжилтийг олгох.

Илрүүлэлт: Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичиг бүрдүүлж архивлаагүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөөгүй, үнэлгээний хорооноос зөвлөмж гаргаж Засаг даргад хүргүүлээгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-д “Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана”, 48.4.6-д “үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж;”, 50.2.3-д “захиалагчид энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх", Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 5.4.10-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, төсөл, арга хэмжээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн холбогдолтой бүх баримт бичиг, комиссын актуудыг хариуцсан албан тушаалтан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивлаж хадгална" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, ажил хариуцсан мэргэжилтнүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэн, чадварыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлэх.

Илрүүлэлт: Цэцэрлэгийн тохижилт, хаалганы засвар, ЕБС-ийн засвар тохижилт, ЕБС-ийн дотуур байрны паркетэн шал солих зэрэг засварын ажлуудад төсөв боловсруулаагүйгээр ажил гүйцэтгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Засгийн газрын 2021 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг мөрдөн ажиллаж, бүтээн байгуулалт, засвар зэрэг ажлуудын батлагдсан зураг, төсвийн дагуу тусгаж хэрэгжүүлэх.

3.2.2 Төрийн сангийн үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт: Сумын ЭМТ-ийн цалингийн зардлаас эмийн үнэ гаргасан, соёлын төвийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлаас бараа материал, шагнал, ЗДТГ-ын бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлаас багаж хэрэгсэл, компьютер худалдан авч байгаа нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал", Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-т "төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн хяналтыг сайжруулах, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийхгүй байх.

3.3 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой /хуулийн байгууллагад шалгуулах/ асуудал

3.3.1 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёлын төвийн сандал нийлүүлэх 55,000.0 мянган төгрөгийн өртөгтэй тендерийг үнэлгээний хороо хуралдуулалгүйгээр Дайчин гүн ХХК-д олгосон нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.2.3-д "захиалагчид энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх", 51.2-д "Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ", 27 дугаар зүйлийн 27.1-д "Захиалагч шаардлагад нийцсэн тендерийг энэ хуулийн 11.4-т заасан үнэлгээний үндсэн шалгуурын дагуу үнэлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

Илрүүлэлт: 2024 онд "ЕБС-ийн засвар тохижилт", "ЕБС-ийн дотуур байрны паркетэн шал солих" гэсэн 2 тендерийг зохион байгуулахдаа хэрхэн үнэлсэн талаар баримт материал ХОА-2025/015/-НА-СТА-ТТЗ

байхгүй, цахимаар ирүүлсэн материалыг задалж нээн үзээгүйгээр шалгаруулж гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Засгийн газрын 2021 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэлт: Хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан	1	82,559.9			1	82,559.9	1	82,559.9				
Хоршоо хөгжүүлэх сан	Тухайн жилд ногдох хүү, алданги тооцож тайланд тусгаагүй	1	5,444.6	1	5,444.6			1	5,444.6				
Орон нутгийн хөгжлийн сан	Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө, нийт эх үүсвэрээс зөрүүтэй	1	5,504.3			1	5,504.3	1	5,504.3				
Орон нутгийн хөгжлийн сан	Үр дүнгийн тайлангийн орлого, зарлагыг зөрүүтэй тайлагнасан.	1	146,210.5			1	146,210.5	1	146,210.5				
Орон нутгийн хөгжлийн сан	Төсвийн гүйцэтгэлийн тайлан төлөвлөгөөгүй, эх үүсвэр байхгүй, зарлагын дүн зөрүүтэй тайлагнасан.	1	717,314.0			1	717,314.0	1	717,314.0				
Орон нутгийн хөгжлийн сан	Хүлээн аваагүй, ажил бүрэн хийгдэж дуусаагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрсөн.	1	117,370.5			1	117,370.5	1	117,370.5				
ДҮН		6	1,074,403.8	1	5,444.6	5	1,068,959.2	6	1,074,403.8				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Орон нутгийн хөгжлийн сан	Соёлын төвийн сандал нийлүүлэх тендерийг үнэлгээний хороо хуралдуулалгүйгээр олгосон.	1	55,000.0								1	55,000.0

	2024 онд "ЕБС-ийн засвар тохижилт", "ЕБС-ийн дотуур байрны паркетэн шал солих" гэсэн 2 тендерийг зохион байгуулахдаа хэрхэн үнэлсэн талаар баримт материал байхгүй, цахимаар ирүүлсэн материалыг задалж нээн үзээгүйгээр шалгаруулж гэрээ байгуулсан.	1	63,144.5							1	63,144.5
	ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээний гэрээ байгуулан санхүүжилт олгохдоо 70:30 харьцаагаар олгож байна.	1	0					1	0		
	Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичиг бүрдүүлж архивлаагүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөөгүй, үнэлгээний хорооноос зөвлөмж гаргаж Засаг даргад хүргүүлээгүй байна.	1	0					1	0		
	Цэцэрлэгийн тохижилт, хаалганы засвар, ЕБС-ийн засвар тохижилт, ЕБС-ийн дотуур байрны паркетэн шал солих зэрэг засварын ажлуудад төсөв боловсруулаагүйгээр ажил гүйцэтгэж байна.	1	0					1	0		
	Цэцэрлэгийн тохижилт, хаалганы засварын ажлыг 2025.03.31-нийг дуустал сунгасан байхад эцсийн санхүүжилтийг олгосон, эцсийн санхүүжилт олгохдоо журам зөрчиж улсын комиссын актгүй, хүлээн аваагүй байхад олгосон, барьцаа чөлөөлөхдөө журамд заасан баримт бичигт үндэслэхгүйгээр олгож байна.	1	161,363.9			1	161,363.9				
Төвлөрүүлэн захирагч	Сумын ЭМТ-ийн цалингийн зардлаас эмийн үнэ гаргасан, соёлын төвийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардлаас бараа материал, шагнал, ЗДТГ-ын БГАҮТХ 210801-ээс багаж хэрэгсэл, компьютер худалдан авч зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.	1	21,109.8					1	21,109.8		
	ДҮН	7	300,618.2			1	161,363.9	4	21,109.8	2	118,144.5

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1					1	
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1					1	